



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

Төрийн ордон, Жанжин Д. Сүхбаатарын талбай 1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 70 16, Факс: (976-11) 32 70 16,
Цахим шуудан: stategreathural@parliament.mn,
Цахим хуудас: www.parliament.mn

2026.09.14 № 56

Улсын Их Хурлын 2026 оны
15 дугаар тогтоолын хэрэгжилт, хүний
эрхийн баталгааны талаар

Монгол Улсын Их Хурлаас 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдөр “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрч байгаа системийн зөрчил, хүний эрхийн баталгааг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 15 дугаар тогтоолыг баталсан.

Уг тогтоолоор эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримтыг бүрдүүлэх, үнэлэхэд гарч байгаа алдаа дутагдал, хууль зүйн туслалцаа авах эрхийг зөрчиж, хязгаарлаж байгаа явдал, хүний халдашгүй байх эрх зөрчигдөх нөхцөл, хууль зөрчсөн шийдвэр, шүүхийн хараат бус байдалд эргэлзээ үүсгэх нөхцөл, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэтрүүлэн хэрэглэж байгаа явдал нь тухайн тохиолдол бүрийн алдаа бус, системийн шинжтэй доголдол болохыг тэмдэглэж, тэдгээрийг арилгах, хүний эрхийн баталгааг бодитой хангах чиглэлээр бодлогын болон зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт үүрэг болгосон.

Засгийн газраас тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хүрсэн үр дүн болон цаашид хэрэгжүүлэх ажлын талаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн дараах асуулгыг тавьж байна.

1. Монгол Улсын Их Хурлын 2026 оны 15 дугаар тогтоолын 2 дахь хэсэгт заасны дагуу тогтоолын 1 дэх хэсэгт тусгасан зохион байгуулалтын болон хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр арга хэмжээний төлөвлөгөө боловсруулсан эсэх, (боловсруулсан бол уг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээ тус бүрийн хариуцах байгууллага, хэрэгжүүлэх хугацаа, шалгуур үзүүлэлт болон өнөөгийн хэрэгжилтийн талаар);

2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчгүйгээр байцаалт явуулах, мэдүүлэг авах хууль бус явдлыг таслан зогсоох, байцаалт бүрийг өмгөөлөгчийн оролцоотой явуулсан эсэхийг бүртгэлжүүлэх, зөрчлийг улирал тутам тайлагнах, илэрсэн зөрчилд хариуцлага ногдуулах нэгдсэн журам батлан мөрдүүлэх чиглэлээр авсан арга хэмжээ, холбогдох журам батлагдсан эсэх, тогтоол батлагдсанаас хойш өмгөөлөгчгүйгээр байцаалт, мэдүүлэг авсан хэчнээн тохиолдол бүртгэгдэж, хэдэд нь хариуцлага тооцсон талаар;

2026000164

3.Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хэрэглээг хуульд заасан үндэслэл, шалгуурт нийцүүлэн хязгаарлах, цагдан хорих шийдвэрийн үндэслэл, хугацаа, сунгалтыг нэгдсэн сангаар бүртгэх, сар бүр хяналт, шинжилгээ хийх, үндэслэлгүй хэрэглэсэн тохиолдолд хариуцлага тооцох тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр ямар ажил хийсэн, нэгдсэн мэдээллийн сан бүрдсэн эсэх, тогтоол батлагдахаас өмнө болон дараа цагдан хорих арга хэмжээний хэрэглээ хэрхэн өөрчлөгдсөн, шалгуурт нийцээгүй болон үндэслэлгүй цагдан хорьсон хэдэн тохиолдол илэрч, хэдэд нь хариуцлага тооцсон талаар;

4.Эрүү шүүлт тулгах болон бусад хэлбэрээр хүнлэг бус, хэрцгий харьцаж авсан мэдүүлгийг нотлох баримтаар тооцохгүй байх хуулийн зохицуулалтын хэрэгжилтийг хангах, нотлох баримтын хууль ёсны байдлыг прокурорын хяналтын шатанд урьдчилан хянах механизм бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, тогтоол батлагдсанаас хойш хууль бус аргаар олж авсан үндэслэлээр прокурорын болон шүүхийн шатанд нотлох баримтаас хассан тохиолдлын тоо, үндэслэл, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцсон эсэх талаар;

5.Эрүүгийн хэрэг хаах, сэргээх, хөөн хэлэлцэх хугацаа тооцох асуудлаарх хууль хэрэглээний зөрүүг арилгах нэгдсэн тайлбар, аргачлал батлан мөрдүүлэх, шүүх, прокурорын практикт гарч байгаа зөрүүг тогтмол нэгтгэн дүгнэх чиглэлээр хийсэн ажил, мөн прокурор, мөрдөгчийн хүний эрхийн мэдлэг, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалт, гүйцэтгэлийн үнэлгээг хүний эрхийн шалгуур үзүүлэлттэй уялдуулах, сахилга, хариуцлагын тогтолцоог бодитоор хэрэгжүүлэх чиглэлээр хүрсэн үр дүнгийн талаар;

6.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах бие даасан албыг шинээр байгуулах асуудлыг тусгасан холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулах ажлын явц, уг албаны бүтэц, харьяалал, чиг үүрэг, үйл ажиллагааны хараат бус байдлыг хэрхэн хангахаар төлөвлөсөн, уг хуулийн төслийг тогтоолд заасан хугацаанд Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлээгүй шалтгаан болон хэзээ өргөн мэдүүлэх талаар;

7.Эрүү шүүлт, хууль бус баривчилгаа, хилс ял, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчлөөс хохирсон иргэдийн эрхийг сэргээх, нөхөн төлбөр олгох, эрүүл мэнд, сэтгэл зүй, нийгмийн үйлчилгээ үзүүлэх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, боловсруулсан хууль тогтоомжийн төсөл, нөхөн төлбөр олгох болон хохирогчид төрөөс үйлчилгээ үзүүлэх тогтолцоог хэрхэн бүрдүүлэхээр төлөвлөсөн талаар;

8.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд яллах чиг баримжаа давамгайлсан тэнцвэр алдагдсан тогтолцоог өөрчлөх хүрээнд прокурорын зарим чиг үүргийг шүүхэд шилжүүлэх, мөрдөн шалгах ажиллагаанд шүүхийн хяналтыг тодорхой болгох, прокурор, өмгөөлөгчийн шүүхийн өмнө тэгш байх зарчмыг хангах, өмгөөллийн үйл ажиллагааг хүний эрхийн хамгаалалтын бие даасан механизм болгох чиглэлээр боловсруулсан санал, судалгаа, хууль тогтоомжийн төслийн явц болон Хууль зүйн байнгын хороонд танилцуулах бэлтгэл ажлын явцын талаар;

9.Мөрдөгч, прокурорын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан хүний эрхийн болон хуулийн зөрчилд хариуцлага зайлшгүй хүлээлгэх механизм, эрүү шүүлт тулгах гэмт хэргийн улмаас хохирсон иргэдэд төрөөс олгосон нөхөн төлбөрийг буруутай этгээдээр буцаан төлүүлэх эрх зүйн орчин, эрүү шүүлт

тулгах гэмт хэрэг үйлдсэн этгээдийн мэдээллийн нэгдсэн бүртгэлийг бүрдүүлэх чиглэлээр хийсэн ажил, тогтоол батлагдсанаас хойш төрөөс олгосон болон буруутай этгээдээс буцаан төлүүлсэн нөхөн төлбөрийн хэмжээ, холбогдох тохиолдлын тооны талаарх мэдээлэл;

10.Цагдаагийн байгууллагын алба хаагчдыг эрүү шүүлт тулгах гэмт хэрэг болон хүний эрх, эрх чөлөөний зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр тасралтгүй сургалт, давтан бэлтгэлд хамруулах, байцаалт, мэдүүлэг авах ажиллагаанд дуу-дүрсний бичлэг хийх, өмгөөлөгчийн оролцоог хангах, алба хаагчдыг хууль зөрчих нөхцөлд хүргэдэг ажлын ачаалал, гүйцэтгэлийн дарамтыг бууруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, сургалтад хамрагдсан алба хаагчдын тоо, дуу-дүрсний бичлэг хийсэн байцаалт, мэдүүлгийн эзлэх хувь, мөрдөгч, алба хаагчдын ажлын ачааллын өөрчлөлт болон эдгээр арга хэмжээний бодит үр дүнгийн талаар.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацаанд, дээрх асуулт тус бүрээр холбогдох тоо баримт, шийдвэр, журам, судалгаа, тайлан болон хэрэгжилтийг нотлох бусад мэдээллийн хамт бичгээр ирүүлэхийг хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains the text "МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН" (State Great Khural of Mongolia) and "ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ" (Law on Monitoring and Evaluation) in Mongolian script. Below the signature, the name "С.ЭРДЭНЭБОЛД" is printed.

С.ЭРДЭНЭБОЛД

2026000164